



# Хагас жилийн тайлан

---

Ард Санхүүгийн Нэгдэл ХК

MSE: AARD



## Гүйцэтгэх Захирлын илгээлт

### **Эрхэм хувьцаа эзэмшигч, харилцагч, түншүүд ээ,**

2025 оны эхний хагас жилд Монгол Улсад улс төрийн томоохон өөрчлөлтүүд гарлаа. УИХ-ын ээлжит бус чуулганы шийдвэрээр шинэ Засгийн газар байгуулагдаж, 18 сайдаас 11 нь шинээр томилогдов. Энэ нь шинэчлэлийн эрмэлзлийг илтгэж буй боловч улс төр, эдийн засгийн бодлогын залгамж чанар хадгалагдаж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар анх удаа бизнесийн төлөөллүүдэд Засгийн газрын бодлого, чиглэлээ Монголын Эдийн Засгийн Форум 2025-ын хүрээнд ил тод танилцуулсан нь нээлттэй, хамтын ажиллагаанд суурилсан шинэ хандлагын илрэл байлаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 үндэсний хэмжээний мега төсөл улс төрийн шилжилт, өөрчлөлтөөс үл хамааран хэвийн хэрэгжиж байгаа нь хөрөнгө оруулагчдын итгэлийг дэмжих гол хүчин зүйлсийн нэг болж байна. Эдгээр төслүүд нь хил дамнасан төмөр зам, эрчим хүч, ашигт малтмалын боловсруулалт, стратегийн нөөцийн олборлолт зэрэг голлох салбаруудыг хамардаг бөгөөд экспортын орлогыг 2 дахин нэмэгдүүлж, логистикийн зардлыг 50 хувиар бууруулах замаар эдийн засгийн өсөлт болон төсвийн тогтвортой байдалд бодитой хувь нэмэр оруулах юм.

Улаанбаатар хотын хувьд, олон жил шийдлээ хүлээсэн авто замын түгжрэл, агаарын бохирдол, дэд бүтцийн хомсдлыг бууруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд 24 томоохон төсөл хэрэгжиж эхлээд байна. Үүнд 2025–2032 онд хэрэгжих Туул усан цогцолбор, Шинэ тойруу зам, Туулын хурдны болон экспресс зам, метро, трамвай, дүүжин зам зэрэг олон улсын стандарт хангасан, үр ашигтай тээврийн шийдлүүд багтаж байгаа юм. Эдгээр төслүүдийг 2030 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд J.P. Morgan, UK Export Finance зэрэг дэлхийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагууд Монгол Улсад хийж буй хөрөнгө оруулалтаа улам тэлэхээ Форумын үеэр мэдэгдсэн нь анхаарал татаж байна.

Эдийн засаг, улс төрийн орчны залгамж чанар, тогтвортой байдал ийнхүү хадгалагдаж буй нь Ард Санхүүгийн Нэгдлийн төдийгүй бизнесийн орчинд эерэгээр нөлөөлж байна. 2025 оны эхний хагас жилд бид бүтцийн оновчлолоо амжилттай дуусгасан нь онцлох амжилт байлаа.

Мөн 4 сарын сүүлээр бид “Хөрөнгө Оруулагч Үндэстэн – Хөрөнгө оруулалтын 7 хоног” арга хэмжээг Сэнтрал Тауэр дахь оффистоо зохион байгуулж, нийт 1,300 гаруй хувьцаа эзэмшигч, харилцагчид идэвхтэй оролцлоо. Уг долоо хоногийн хүрээнд харьяа компаниудын 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг танилцуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлуудыг зохион байгуулж, дараах стратегийн хэлцэл, түншлэлүүдийг зарлав:

- Даатгал болон тэтгэврийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах шинэ холдинг компани болох Өндөрхаан (ОНН)-д Ард Даатгалын 50 хувийн хувьцааг 20 тэрбум төгрөгөөр худалдах гэрээг байгууллаа;
- Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг буцаан худалдан авч буюу халааслаж, Хөвсгөл (AIG) компанийн хувьцаагаар төлбөр тооцоог хийх замаар бүтцийн шинэчлэлтийг хэрэгжүүллээ;
- Монгол Шуудантай хамтран орон нутагт иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх санаачилга;
- "ЦойлогсоZ" нэртэй 2,500 гаруй залуусын нэгдэлтэй хамтран залуучуудын хэрэгцээнд нийцсэн ЖДҮ-ийн санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнийг танилцууллаа.

2005 онд ХасБанкны ажилтнуудын хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр үүсгэн байгуулагдсан И Ай Ти компани нь 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл болон шинэчлэгдэж, бие даасан санхүүгийн нэгдлийн үндэс суурийг тавьсан билээ. Үүнээс хойшхи 12 жилийн хугацаанд бид банк санхүү, технологи, дэд бүтцийн салбаруудад тогтвортой хөрөнгө оруулалт хийж, нийт 44 компанийг нэгтгэн, Ардын хөрөнгийг ₮30 тэрбумаас ₮380 гаруй тэрбумд хүргэн өсгөсөн байна. Мөн бид 2016 оноос эхлэн "Хөрөнгө Оруулагч Үндэстэн" хөдөлгөөнийг эрчимжүүлж, Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд багагүй хувь нэмэр оруулж, олон анхдагч ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Бидний үндсэн зорилго болох бүх төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг салбаргүйгээр бүрэн цахим хэлбэрээр хүргэх зорилт 2019 онд Ард Аппын анхны хувилбар гарснаар биелэлээ олж, 2024 оны эцэст бүх боломжит бүтээгдэхүүн, үйлчилгээг сууриас нь авхуулаад хэрэглэгчийн гарт хүрэх хүртэл бүрэн цахимжуулснаар суурь бэлтгэлийн үе шат амжилттай дуусч, бүтцийн оновчлолын дараагийн шат руу шилжсэн.

Хоёр жилийн турш үргэлжилсэн бүтцийн оновчлолын ажил дуусгавар болж, санхүүгийн бус компаниудыг төвлөрүүлсэн Хөвсгөл ХК (AIG)-ийн хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл (MSE:AARD)-ийн хувьцаагаар сольж, хөрвүүлэх ажлыг амжилттай хийснээр тус хоёр нэгдэл нь тусгаарлагдаж буй юм. AIG нь удирдлагын

багаа бүрдүүлж, хөрөнгө оруулалтын багцаа илүү оновчтой болгож, ухаалаг хот, уул уурхай, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бүтэц зохион байгуулалтаа дуусгасны араас бид дараагийн үе шат буюу Сингапурт байгуулсан Ард Холдингс Интернэшнл компаниар дамжуулан хөрөнгө босгох ажил руу шилжсэн. Ингэснээр бид гол компаниуд, хөрөнгүүдээ тус компанийн дор нэгтгэж, олон улсад өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлээ нэвтрүүлэх суурь тавигдах юм. 6 сарын эхээр бид "Хөрөнгө Оруулагч Үндэстэн - Европ" бизнес уулзалтын хүрээнд Цюрих, Мюнхен, Франкфурт, Парис, Женев зэрэг 5 хотод нийт 130 хөрөнгө оруулагчидтай уулзалт хийж, Ардын ирээдүйн стратеги болон хөрөнгө оруулалтын боломжуудыг танилцуулсан болно.

## Мөнгөний бодлого чангарч, санхүүгийн зах зээл хумигдав

2025 оны эхний улиралд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2.4 хувь болж саарсан бөгөөд эхний хагас жилийн нүүрсний экспортын хэмжээ өмнөх оны мөн үеээс 45 хувиар буурсан нь бүхий л салбарт сөргөөр нөлөөллөө. Харин зэсийн экспорт түүхэн дээд хэмжээндээ хүрснээр эдийн засгийн хүндрэлийг сааруулах нэг хүчин зүйл болсон. Хоёрдугаар хагас жилд нүүрсний үнэ болон экспортын хэмжээ сэргэх хүлээлттэй байгаа бөгөөд Азийн Хөгжлийн Банкны таамаглалын дагуу Монгол Улсын эдийн засгийн жилийн өсөлт 6.6 хувьд хүрэх төлөвтэй байна.

Инфляц 2025 оны 2 сард 9.4 хувьд хүрсэн дээд цэгээс бага зэрэг буурч, 6 сард 8.2 хувьтай байсан нь өнгөрсөн оны мөн үеийн 4.6 хувиас өндөр хэвээр байна. Инфляцын өсөлтийн гол шалтгаанууд нь ханшийн нөлөө, цахилгаан, дулаан зэрэг зохицуулалттай тарифын өсөлт, мөн 4 сарын 1-нээс хэрэгжсэн цалингийн доод хэмжээний 20 хувийн нэмэгдэлтэй холбоотой дотоод эрэлтийн өсөлт байв.



Инфляцын дарамтыг хязгаарлах зорилгоор Монголбанк оны эхэнд 2 пункт нэгжээр нэмэгдүүлсэн бодлогын хүүг 12 хувьд хадгалсан. Мөн хэрэглээний зээлийг хязгаарлах, инфляцыг тогтворжуулах зорилоготой макро хатуу бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнтэй зэрэгцэн Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) банк бус санхүүгийн байгууллагууд, ялангуяа финтек платформуудын зээл, эх үүсвэр татан төвлөрүүлэлтийн үйл ажиллагаанд дараах хязгаарлалт тавьсан нь:

- Итгэлцэл, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг олон нийтээс хөрөнгө татах боломжуудын хязгааруудыг бууруулсан;
- Дотоодын санхүүгийн байгууллага хоорондын зээлийн харилцааг хязгаарласан;
- Хэрэглээний зээлийн өр-орлогын харьцааг бууруулсан;
- Нэг хэрэглэгч тухайн цаг хугацаанд зөвхөн нэг онлайн зээл авах хязгаар тогтоосон.

Эдгээр арга хэмжээний үр дүнд ч Төв банкны инфляцын зорилтот түвшин болох  $6\pm 2$  хувийн дээд хязгаарын ойролцоо хэвээр хадгалагдах төлөвтэй байгаа бол эсрэгээрээ зах зээл дээрх хөрөнгө босголтын өртөг нэмэгдэх хандлагатай байна.

Ийм нөхцөлд Ард Санхүүгийн Нэгдэл уян хатан зохицуулалт хийж, бүтцийн оновчлолоо дуусган, стратегийн хэлцэл, түншлэлүүдийг хэрэгжүүлснээр голлох үзүүлэлтүүдээ тогтвортой, эерэг түвшинд хадгалж чадлаа.

Тухайлбал:

Ард Кредитын нийт хөрөнгө 2025 оны II улирлын эцэст ₮122.9 тэрбумд хүрч, жилийн эхнээс ₮7.4 тэрбум буюу 6.4 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс ₮39.2 тэрбум буюу 46.9 хувиар өссөн. Мөн бид өнгөрсөн оны эцсээс хойш гадаадын санхүүжилт хайж, өмнө нь хамтран ажиллаж байсан Crowd Credit-ээс 5 сая доллартай тэнцэхүйц санхүүжилтыг 1 жилийн хугацаанд татан төвлөрүүлэхээр болов. Харин зээлийн багц 2025 оны эхний хагаст ₮3.5 тэрбум буюу 5 хувиар буурч, ₮64 тэрбум болсон нь чанаргүй зээлийн хэмжээ өссөн болон нэг хэрэглэгч

тухайн цаг хугацаанд нэг онлайн зээл авах хязгаарлалтаас шалтгаалсан. Гэсэн ч Ард Кредит 2025 оны эхний хагас жилд ₮1.7 тэрбумын цэвэр ашигтай ажиллаж, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс даваад байна.

Ард Актив нийт хөрөнгөө ₮62.7 тэрбумд хүргэж, жилийн эхнээс 9.5 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 23.3 хувиар өсгөв. Зээлийн багц ₮49.1 тэрбум болж, жилийн өсөлт 18.5 хувьтай байсан бол хадгаламж ₮48.6 тэрбумд хүрчээ. Эхний хагас жилд ₮615 саяын цэвэр ашиг олсон нь 2024 оны мөн үеийн ашигтай харьцуулахад даруй 2 дахин өссөн үзүүлэлт юм. Гишүүдийн тоо 1,104-өөр нэмэгдэж, нийт 5,571 хүрсэн.

Ард Лизинг нийт ₮10 тэрбумын багцад хүрч, гол бүтээгдэхүүн болох Өсдөг Машин буюу 5 жилийн хугацаатай, урьдчилгаа 5 хувийн нөхцөлтэйгээр хувьцаа болон ардкойн (ARDX) худалдан авах бүтээгдэхүүнийг эхний хасагт ₮5 тэрбумыг борлуулав. 2025 оны II хагаст нэмэлтээр ₮7 тэрбумын багцыг борлуулж, шинэ лизингийн бүтээгдэхүүн нэвтрүүлэн орлогоо төрөлжүүлэхээр төлөвлөж байна.

## Хөрөнгийн зах зээл хөгжил...

2025 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн зах зээл хосолсон хандлага үзүүллээ:

- Анхдагч зах зээлийн идэвх суларснаар нийт арилжааны хэмжээ ₮430.2 тэрбум болж, жилийн өмнөхтэй харьцуулахад 46 хувиар буурав;
- Харин хоёрдогч зах зээлийн арилжаа 35 хувиар өсөж, ₮293.4 тэрбумд хүрчээ.
- Тогтмол орлоготой үнэт цаас нь хувьцаанаас илүү сонирхол татсан хэвээр байна.

**Арилжааны төрлөөр ангилбал:**

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 39.1 хувь;

- Хувьцаа 25.9 хувь;

- Компанийн бонд 20.5 хувь;

- Засгийн газрын бонд 13.5 хувь;

- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Зах зээлийн нийт үнэлгээ ₮872.6 тэрбумаар өсөж, жилийн өмнөх үетэй харьцуулахад 7.7 хувиар нэмэгдэж, ₮12.2 их наяд хүрсэн. Үүнээс Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн (UBX) үнэлгээ ₮22.9 тэрбум байна. TOP-20 индекс II улиралд 48,725.1 нэгж дээр хаагдаж, жилийн өсөлт 13 хувьтай байлаа. Энэ нь гол хувьцаанууд дахь хөрөнгө оруулагчдын итгэл сэргэснийг илтгэнэ.

Ард Секюритиз нь дотоод бүтэц, хөрөнгийн зах зээлийн томоохон хэлцлүүдийг үргэлжлүүлэн удирдахын сацуу гадны байгууллагад үйлчилгээ үзүүлж эхэллээ. Ард Инвестмент Групп, Өндөрхаан, ОТС болон олон нийтэд санал болгох бондын үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Гэвч 2025 оны эхний хагас жилд брокерын арилжааны хэмжээ зах зээлийн идэвх сул байсантай холбоотойгоор ₮20 тэрбум болж, өмнөх оныхоос 30 хувиар буурсан. Үүний ₮9 тэрбумыг Ард Аппаар дамжуулан хийсэн. Компанийн зорилго нь бүтээгдэхүүнээ автоматжуулах, олон улсын зах зээлийн арилжааг нэвтрүүлэх, вэб платформыг нэвтрүүлэхэд чиглэж байна. Мөн судалгааны баг зах зээлийн мэдээлэл, дүгнэлтийг тогтмол нийтэлж, Хятадын SXCoal сайтад хэд хэдэн нийтлэл хүргээд байна. Компанийн үйл ажиллагаа эхний хагас жилд ашиг, алдагдал тэнцсэн байдалтай байна.

Ард Менежментын хувьд хамтын нээлттэй болон хаалттай сангуудаа удирдахын зэрэгцээ хаалттай сан үүсгэн байгуулах ажлыг эхлүүлж, Монголын хөрөнгө оруулагчдаа Сингапурын компанид хувьцаа эзэмших боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Мөн бид алго-арилжааг дотооддоо судлан туршиж, тус бүтээгдэхүүнийг ойрын хугацаанд үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зэхэж байна.

**Өндөрхааны ирээдүй-үр өгөөж**

Бүтцийн оновчлолын хүрээнд бид хэт олон тоглогчтой даатгалын салбарт ойрын ирээдүйд бий болох нэгтгэх шаардлага болон тэтгэврийн сангийн эрх зүйн шинэчлэлд бэлтгэн, Өндөрхаан компанийг даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагааг нэгтгэсэн нээлттэй холдинг компанийн бүтэцтэй болгон дахин зохион байгуулж байна.

Ард Даатгал ISO:9001 болон ISO:27001 олон улсын стандартуудыг хэрэгжүүлж, салбарын бусад оролцогчидтой хамтран хамтарсан баталгааны даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ. 2025 оны эхний хагас жилд нийт даатгалын хураамжийн орлого ₮20.3 тэрбум болсон нь өнгөрсөн оны мөн үеэс ₮2 тэрбумаар буурсан үзүүлэлт юм. Энэ нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хуулийн өөрчлөлтөөр хураамжийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх шийдвэр гарсан ч олон нийтийн эсэргүүцлийн улмаас хүчингүй болгосон нь уг бүтээгдэхүүний алдагдлыг нэмэгдүүлж, компанийн энэ сегментэд эзлэх оролцоог багасгах шийдвэр гаргахад хүргэсэнтэй холбоотой. Компанийн цэвэр ашиг ₮767 саяд хүрч, 2024 оны мөн үеийнхээс 25 хувиар давсан байна. Компанийн нийт хөрөнгө ₮50 тэрбумыг давсан бөгөөд үүнээс ₮32 тэрбумыг хөрөнгө оруулалтад, тэр дундаа ₮26 тэрбумыг тогтмол орлоготой үнэт цаас болон хадгаламжид байршуулсан. Даатгалын нөхөн төлбөрийг өдгөө шууд Ард Аппаар дамжуулан олгож эхэлсэн нь харилцагчдад илүү хялбар бөгөөд шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж байна.

Ардын Тэтгэврийн Сан одоогоор нийт 141,416 харилцагчийн тэтгэврийн хуримтлалыг удирдаж байна. Үүнд 112 аж ахуйн нэгж байгууллагын 2,300 гаруй ажилтан багтана. 2025 оны эхний хагас жилд ₮5.1 тэрбумын

тэтгэврийн хуримтлал төвлөрүүлсэн бөгөөд ₮1.3 тэрбумын тэтгэвэр олгот хийгдсэн байна. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл УИХ-ын чуулганаар хэлэлцэгдэж, тэтгэврийн санд бодит реформ хийх нь цаг хугацааны асуудал болоод байна. Чухам энэ цаг үед Өндөрхааны үр өгөөж хэрхэн ирэх нь сонирхол татаж буй.

## Ард Апп - Санхүүгийн зах зээл дэх технологийн тэргүүлэгч хэвээр байна

Сүүлийн 2 жилийн хугацаанд бид Ард Аппын V хувилбарыг хөгжүүлэхдээ бүтээгдэхүүн худалдан авах үйл явцыг хялбаршуулах, дэлгэцийн тоог цөөлөх, үйлчилгээг автоматжуулах, техникийн саатал, алдааг засварлах зэрэгт гол анхаарлаа хандуулж, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахад төвлөрөн ажиллалаа. Энэхүү ахиц дэвшил дээр тулгуурлан бид одоо Ард Аппын VI хувилбарын хөгжүүлэлтийг эхлүүлээд байна. Шинэ хувилбар нь UI/UX мэргэжилтнүүдийн оролцоотойгоор бүрэн шинэчилсэн интерфэйс болон, илүү ардкойн (ARDX) төвтэй, жигд, ухаалаг, хялбар хэрэглээг бий болгож, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох хэрэгсэл болон хөгжиж байна. Уг шинэ хувилбарыг 2025 оны эцэст зохион байгуулагдах Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулганы үеэр танилцуулахаар төлөвлөж байна.

Бид 2023 оны сүүлээр Ард Аппын хэрэглэгчдийг нэгтгэх зорилгоор Түмэн Ард хөтөлбөрийг санаачилсан билээ. Одоогийн байдлаар Түмэн Ардынхан 10,000 гаруй идэвхтэй гишүүнтэй болж, Ард Апп дахь бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан борлуулж, өөрийн багийг тэлэхийн төлөө идэвхтэй ажиллахын зэрэгцээ санхүүгийн боловсролыг орон даяар түгээх, санхүүгийн зөв дадал зуршлыг хэвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Хөтөлбөрийн үр дүнд эхний хагаст ₮13.9 тэрбумын борлуулалт хийгдэж, Ард Аппын нийт борлуулалтын 50 хувийг бүрдүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4 дахин өссөн үзүүлэлт юм. Мөн энэ хугацаанд бид дотоод дуудлагын төвийн үйл ажиллагааг зардлын оновчлолын хүрээнд МОСТ Финтек компанид шилжүүллээ. МОСТ нь өөрийн түнш байгууллагуудад дуудлагын төвийн үйлчилгээ

үзүүлэхэд бэлтгэгдсэн учир энэ шийдэл нь үр ашигтай байлаа. Үүний үр дүнд манай охин компаниуд илүү зардал мэдрэмжтэй, автоматжуулалт ашиглан хэрэглэгчийн дуудлагын тоог бууруулахыг эрмэлзэх болсон. МОСТ-ын дуудлагын төв бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлмэгц нэмэлт хэрэглэгчдэд үйлчлэх боломжтой болж, бидний нийт зардлыг бууруулах давуу тал үүснэ.

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох үйл хэргийг дэмжиж буй хувьцаа эзэмшигч, Түмэн Ардын гишүүд, харилцагч, түншүүддээ талархаж явдгаа илэрхийлье. Бидний бүтээн байгуулсан илүү өргөжин тэлэх боломж бүхий бүрэн цахим платформын суурь тавигдан дуусаж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэн зах зээл дэх байр сууриа улам бэхжүүлж эхэллээ. Бид Монгол орны өнцөг булан бүрт бүхий л санхүүгийн хэрэгцээг хангах ажлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өөрсдийн бүтээсэн шийдлээрээ олон улсын зах зээлд өрсөлдөх үе шатанда яваагаа дуулгахад таатай байна. Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2025 Чуулганаар уулзацгаая.

**Батбилэгийн Золбоо**  
Гүйцэтгэх Захирал

2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдал

---




Даатгал болон Хувийн Тэтгэврийн Сангийн Нэгдэл ӨндөрХаан ХК (MSE:ONH) үүсгэн байгуулагдав.



Ард Кредит, Монгол шуудан хамтран ухаалаг ПОС системээр дамжуулан санхүүгийн үйлчилгээ хүргэхээр болов.



Монголын анхны Хувьцаа солих шийдлийг олгосноор Медиа, Технологи, Програм хангамж, Блокчэйд суурилсан бизнесийг удирдах Хөвсгөл ХК (HVL>>>AARD) -ийн хувьцааг эзэмших боломжийг нээв.



Япон Улсын Крауд Кредит сантай USD5 сая долларын санхүүжилтийн хэлэлцээр хийв.



Монголын Триатлоны холбоотой 5 жил үргэлжлэх стратегийн түншлэлийн гэрээ байгуулав.



Ард Кредит - ЦойлогсоZ залуусын нэгдэлтэй хамтран залуу бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллав.




MEF YOUTH 2025 Форумд ерөнхий ивээн тэтгэгчээр оролцов.



CAMCA (Central Asia-Mongolia-Caucasus-Afghanistan) бүсийн форумд ивээн тэтгэгчээр оролцов.

## 5 ӨДӨР - 5 ХОТ - 130 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

Бид сүүлийн 3 жилийн хугацаанд бүтцийн өөрчлөлт хийж, голлох дижитал шилжилтүүдээ амжилттай хийж гүйцэтгэснээр бүтээсэн ажил, хойшид хүрэх зорилтыг Олон улсад хүртээмжтэй түгээх зорилгын хүрээнд Цюрих, Мюнхен, Франкфурт, Парис, Женев хотуудад танилцуулав.



## ДАРХАН, СЭЛЭНГЭ, БУЛГАН, ЭРДЭНЭТ, ХЭНТИЙ, БАГАНУУР, САЙНШАНД, ЧОЙР

Монголын өнцөг булан бүрд суугаа Ардын харилцагч нартаа илүү ойроос үйлчилгээ үзүүлж, компанийнхаа үйл ажиллагааг хүртээмжтэй түгээх зорилгоор Ардын баг хамт олон ээлжит аяллаа 6 сарын 22-ноос 6 сарын 27-ны хооронд Дархан, Сэлэнгэ, Булган, Эрдэнэт, Хэнтий, Багануур, Сайншанд, Чойр хотуудыг зорин очиж үйлчилгээ үзүүлэв.



6

ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРАЛ

COMMUNITY  
MEETINGS

ТҮМЭН АРД | ARDX | ARDM  
BS99 | DAXT

КРИПТО,  
ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ

VIP  
EVENTS

ОНЦЛОХ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ОНЦЛОХ  
ТАНИЛЦУУЛГА

САНХҮҮГИЙН  
ЦОГЦ  
ҮЙЛЧИЛГЭЭ

АМА  
Х ССЭНЭЭ АСУУ

ХУВИЙН  
САНХҮҮГИЙН  
СУРГАЛТУУД

КОМПАНИ  
БҮРИЙН  
УРАМШУУЛАЛ

ХӨГЖӨӨНТ  
ТОГЛООМ

## Онцлох танилцуулга

- Мост юу санал болгодог вэ?
- Монгол шуудан - Бизнес төлөвлөгөө, Шинэ үйлчилгээ
- Хөрөнгийн зах зээлийн хөгжил
- Тэнгэрлиг медиа нэгдэл болон Ори студиос
- Крипто банк

## Онцлох хэлэлцүүлэг

- Хөрөнгө оруулж, Хөгжье!
- Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийн төсөл
- Хиймэл оюунд бид бэлэн үү?
- Блокчэйн ба Криптовалют ялгаа: Аюулгүй, ил тод гинжин хэлхээ
- Оновчтой зарцуулах жор

## Онцлох зочид



**Бруно Рашле**  
ТУЗ-ийн гишүүн,  
Ард Санхүүгийн Нэгдэл



**Тьерри Д'Хотуил**  
Хөрөнгө оруулалтын зөвлөх,  
Ард Санхүүгийн Нэгдэл



**Роланд Нэш**  
ТУЗ-ийн гишүүн,  
Ард Санхүүгийн Нэгдэл

## АрдКап 2025 Спорт наадам зохион байгуулагдлаа!

Ард Санхүүгийн Нэгдэл болон хамтран ажилладаг байгууллагуудын ажиллагсдыг спортын уралдаан тэмцээнээр дамжуулан улам нэгдмэл болгох, хамтын уялдаа холбоог бэхжүүлэн эрүүл мэндийг дэмжиж, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготойгоор АрдКап 2025 тэмцээнийг зохион байгуулж, 2025 оны 5 сарын 24-нөөс 6 сарын 08-ны хооронд Спортын 9 төрөлтөөр 15 хоногийн турш өрсөлдсөнөөр ажиллагсдын сэтгэл ханамж, эрүүл мэнд, чөлөөт цагт үнэтэй хувь нэмэр оруулсан үйл явдал боллоо.



## Банкны кластер

### Ард Кредит (MSE:ADB)



### Ард Лизинг



### Ард Актив



## Банкны кластер

- ▲ 38.0% Нийт хөрөнгө **₮185.5 тэрбум**
- ▲ 20.4% Цэвэр зээлийн багц **₮113.8 тэрбум**
- ▲ 19.3% Цэвэр ашиг **₮2.3 тэрбум**



Нийт олгосон зээл  
**₮99.3 тэрбум**

- Онлайн зээл: ₮76.5 тэрбум
- Бизнес зээл: ₮18.5 тэрбум
- Жижиглэн зээл: ₮4.3 тэрбум



● Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил

● Холбоотой этгээдийн эзэмшил

2025 оны 6 сарын 30-ны байдлаар



# ONH

ARD | ДААТГАЛ  
SINCE 1994

ARD | ТЭТГЭВРИЙН  
САН

## Даатгалын кластер


Өндөрхаан (MSE:ONH)



Ард Даатгал (MSE:AIC)



Ардын Тэтгэврийн Сан



## Даатгалын кластер

- ▲ 7.2% Нийт хөрөнгө **₮104.6 тэрбум**
- ▼ (7.6%) Нийт орлого **₮25.4 тэрбум**
- ▲ 7.0% Хөрөнгө оруулалтын багц **₮76.5 тэрбум**

Тогтмол өгөөжтэй үнэт цаас <b>37.8%</b>	Хувьцаат хөрөнгө оруулалт <b>45.9%</b>
Алтернатив хөрөнгө оруулалт <b>15.0%</b>	Бусад хөрөнгө оруулалт <b>1.3%</b>

Идэвхтэй даатгал эзэмшигчид <b>212,280</b>	Тэтгэврийн хуримтлал эзэмшигчид <b>141,416</b>
--	--

● Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил    ● Холбоотой этгээдийн эзэмшил    2025 оны 6 сарын 30-ны байдлаар

## Хөрөнгө Оруулалтын Банкны кластер

### Ард Менежмент



### Үндэсний Хувьчлалын Сан (MSE:XOC)



### Хөрөнгө Оруулагч Үндэстэн Сан (ХОУС)



### Ард Секюритиз



### Ард Пропертиз



## Хөрөнгө оруулалтын банкны кластер

▼ (4.4%) Нийт хөрөнгө	<b>₮40.6</b> тэрбум
▲ 63.2% Санхүүжилт зуучлалын багц	<b>96.4₮</b> тэрбум
▼ (28.3%) Арилжаа зуучлал	<b>₮20.5</b> тэрбум
▲ 16.5% Нийт орлого	<b>₮3.7</b> тэрбум
▲ 23.9% Удирдаж буй хөрөнгө	<b>₮34.0</b> тэрбум

Ард Апп арилжаа **₮8.9 тэрбум**  
Брокерын арилжаа **₮11.5 тэрбум**

● Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил

● Холбоотой этгээдийн эзэмшил

2025 оны 6 сарын 30-ны байдлаар

## Дэд бүтэц

Монгол Шуудан (MSE:MNP)



8.0%

17.6%

МОСТ Финтек



3.4%

40.6%

## Хөвсгөл



AIGROUP - HVL (AIG)

52.7%



● Ард Санхүүгийн Нэгдлийн эзэмшил

● Холбоотой этгээдийн эзэмшил

2025 оны 6 сарын 30-ны байдлаар

ТУЗ-ИЙН ДАРГА

**Ч. Ганхуяг**ТУЗ-ийн дарга,  
Ард Санхүүгийн Нэгдэл

ЕРДИЙН ГИШҮҮН

**А. Сүхдорж**Үүсгэн байгуулагч БСБ Сервис,  
ГрэйпСити Монгол, МОСТ Финтек

ЕРДИЙН ГИШҮҮН

**Бруно Рашле**Дэд Дарга,  
Шродер Капитал Холдинг

ЕРДИЙН ГИШҮҮН

**О. Одбаяр**ТУЗ-ийн дарга,  
Ард Даатгал

ЕРДИЙН ГИШҮҮН

**Б. Золбоо**Гүйцэтгэх Захирал,  
Ард Санхүүгийн Нэгдэл

ХАРААТ БУС ГИШҮҮН

**М. Сэргэлэн**Захирал,  
Монгол Коосэн Технологийн Коллеж

ХАРААТ БУС ГИШҮҮН

**Арно Вентура**Удирдах партнер,  
Гожо энд Ко.

ХАРААТ БУС ГИШҮҮН

**Михиал Зелдович**Хяналтын зөвлөлийн дарга,  
Кокуун капитал

ХАРААТ БУС ГИШҮҮН

**Роланд Нэш**Үүсгэн байгуулагч,  
VPE Капитал

**Б.ЗОЛБОО**

Гүйцэтгэх Захирал

**Г.УЯНГА**Үйл Ажиллагаа Эрхэлсэн Захирал,  
Гүйцэтгэх Захирал, Ард Пропертиз**Ч.АЛТАН-ӨЛЗИЙ**Дата, Судалгаа Эрхэлсэн  
Захирал**Г.БИЛГҮҮН**Санхүү эрхэлсэн захирал,  
Гүйцэтгэх Захирал, Ард Актив**А.АЗБАЯР**

Хөрөнгө оруулалтын зөвлөх

**Х.БИЛГҮҮН**Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн Захирал,  
Гүйцэтгэх Захирал, Ард Секюритиз**М.МӨНХ-ЭРДЭНЭ**Аудит Эрхэлсэн  
Захирал**Ө.АШХҮҮ**Ахлах Хуулийн  
Зөвлөх

**Н. ЭРДЭНЭТУЛГА**


Гүйцэтгэх Захирал,  
Ард Даатгал

**Г.СҮХБААТАР**

Гүйцэтгэх Захирал,  
Ард Кредит

**Ч.ДАВААСАМБУУ**

Гүйцэтгэх Захирал,  
Ард Менежмент

**М.ЭНХЗУЛ**

Хуулийн зөвлөх,  
ТУЗ-ийн Нарийн Бичгийн дарга

**Ц.ТАЙШИР**

Гүйцэтгэх Захирал,  
Ард Тэтгэврийн сан

**Д.МӨНХ-ОД**

Гүйцэтгэх Захирал,  
Ард Лизинг

**Б.ГАНЧИМЭГ**

Гүйцэтгэх Захирал,  
Ард Академи

44

Нийт компани

46

Тусгай зөвшөөрөл

(17.8%)

119,624

Хувьцаа эзэмшигч

(2.2%)

1,103,663

Ард Апп хэрэглэгч

4.65%

58,410

АрдКидс Апп хэрэглэгч

(26.2%)

203,143

Ардкойн эзэмшигч

96.2%

40,468

Зээлийн данс (идэвхтэй)

(13.9%)

212,280

Даатгуулагч (идэвхтэй)

0.9%

141,416

Тэтгэврийн хуримтлал эзэмшигч

1.9%

166,618

Үнэт цаасны данс эзэмшигч

24.8%

5,990

Ард Актив ХЗХ-ны гишүүд

23.7%

10,001

Түмэн Ардын гишүүд

## Технологи

Блокчэйн  
Банкны суурь систем  
Дижитал банк  
Интернэт банк

Урамшууллын систем  
Төлбөрийн шийдэл



## Дэд бүтэц

Шуудан холбоо  
Төлбөр тооцоо  
Медиа нэгдэл  
Хөрөнгийн бирж

**+48,000**  
Мерчант


**+400**  
Салбар

## Уламжлалт санхүү

Банк  
Даатгал  
Хөрөнгө оруулалтын банк

**+1,600,000**  
Харилцагч / Данс





Хэрэглэгч	<b>1,103,663</b> бүртгэлтэй	
Гүйлгээ	<b>₮243 тэрбум</b> +34%	<b>1,811,259</b> (19.5%)
Хуримтлал	<b>₮20.7 тэрбум</b> +15%	<b>368,446</b> +8.2%
Цахим зээл	<b>₮76.7 тэрбум</b> +74%	<b>86,920</b> +110.6%
Арилжаа	<b>₮8.9 тэрбум</b> (49.4%)	<b>44,163</b> (19.9%)



Ард Апп татах



## Ард Апп - Эхний хагас жилд



Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн FICO кредит онооны системийг нэвтрүүлж, хос онооны системийг бүрдүүлэв.




Картын удирдлагын системтэй уялдуулж, дебит картыг хэрэглээнд нэвтрүүлэв.



Хэрэглэгчид Виртуал хөрөнгийг Ард Аппаар шууд худалдан авах боломжтой болов.



UBEats аппликейшнтэй уялдуулснаар хэрэглэгчид Ard App ашиглан хоол захиалж, шууд төлбөр хийх боломж бүрдэв.





**Төлбөр тооцоо:**

QR гүйлгээ - Бүх банкнаас төлбөр хүлээн авах



**Ардкойн урамшуулал:**

Бүх мерчантад төлбөр төлөхдөө 10% ардкойноор төлөх




**Хуваан төлөх үйлчилгээ:**

₮5,000,000 хүртэл дүнгээр хүүгүй, шимтгэлгүй 2-6 удаа хүртэл хуваан төлөх



**Ардкойн урамшуулал:**

Үнийн дүнгийн 1%-д харилцагчаа урамшуулах 10,000 ардкойныг бүх мерчантад бэлэглэв.





Stronger. Together.

	2024 H1	2024	2025 H1	YoY %
<b>АрдКидс бүртгэлтэй хүүхэд</b>	55,864	56,178	56,922	<b>1.9%</b>
<b>Хүүхдийн хадгаламж (₮ тэрбум)</b>	2.8	5.3	3.8	<b>35.7%</b>
<b>Нийт гүйлгээний дүн (₮ сая)</b>	283	901	322	<b>13.8%</b>

Хүүхдийн баярыг тохиолдуулан Хүүхэд цэвэр орчинд дуртай сэдэвт гар зургийн уралдаан болон Хэрвээ би байгаль байсан бол... зохион бичлэгийн уралдааныг зарлаж, Монголын өнцөг булан бүрээс нийт 1,200 гаруй хүүхэд оролцсоноос нийт 68 шилдэг бүтээлийг шалгаруулан бэлэг гардуулав.



АрдКидс апп татах



Түмэн Ард - Түмэн боломж	2024	2025 Н1	Хагас жилийн өсөлт %
 <b>Ардын Альфа</b>	1	2	<b>100.0%</b>
 <b>Ардын Элч</b>	15	24	<b>60.0%</b>
 <b>Ардын Ноён</b>	1,817	2,162	<b>19.0%</b>
 <b>Ардын Брокер</b>	6,254	7,813	<b>24.9%</b>
<b>Түмэн Ардын нийт гишүүд</b>	8,087	10,001	<b>23.7%</b>
<b>Борлуулалт</b>	₮9.6 тэрбум	₮13.9 тэрбум	<b>44.8%</b>

**Түмэн Ард төсөл нь** Ард Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгын хүрээнд Ард Аппаар дамжуулан олон нийтэд санхүүгийн зөв дадал, хуримтлал бий болгох зорилготой хөтөлбөр юм.


2023 оны 12 сарын 15-наас эхлэн амжилттай хэрэгжсэн Түмэн Ард нь санхүүгийн өдөр тутмын хэрэглээндээ Ард Аппыг ашигласнаар гүйлгээ бүрээсээ АрдКойн цуглуулах, Ардын Эрхээ нэмэгдүүлж, орлогын нэмэлт сувагтай болох, Баян Монголыг бүтээх цогц систем юм.



2025 оны эхний хагас жилд ₮61 сая бүхий ардкойн нь Түмэн Ардын гишүүдэд борлуулалтын урамшууллаар тараагдсан байна.

# ТҮМЭН АРД - ТҮМЭН БОЛОМЖ

10,000+



Улаанбаатар: 6,785

Орхон: 432

Дархан-Уул: 287

Төв: 187

Говь-Алтай: 170

Сэлэнгэ: 235

Хөвсгөл: 167

Өвөрхангай: 190

Завхан: 121

Өмнөговь: 142

Дорноговь: 213

Дорнод: 124

Баянхонгор: 131

Булган: 101

Хэнтий: 122

Ховд: 91

Увс: 117

Баян-Өлгий: 53

Архангай: 121

Дундговь: 59

Говьсүмбэр: 65

Сүхбаатар: 87

сая төгрөг	2022	2023	2024	2024 H1	2025 H1	YoY
Менежментийн орлого	2,837	1,886	3,513	1,682	2,129	27%
Хөрөнгө оруулалтын орлого	3,657	5,969	5,590	4,233	1,094	(74%)
Ногдол ашгийн орлого	1,012	45	872	452	8	(98%)
Хүүгийн орлого	18	1,067		503	298	(41%)
<b>Нийт хөрөнгө оруулалтын орлого</b>	<b>7,525</b>	<b>8,967</b>	<b>9,975</b>	<b>6,869</b>	<b>3,529</b>	<b>(49%)</b>
Бусад орлого	6,250	3,024		138	62	(55%)
<b>Нийт орлого</b>	<b>13,775</b>	<b>11,992</b>	<b>9,975</b>	<b>7,007</b>	<b>3,591</b>	<b>(49%)</b>
Борлуулалт, маркетингийн зардал	2,228	1,193	686	22	28	29%
Үйл ажиллагааны зардал	5,667	7,776	5,517	2,873	2,409	(16%)
Санхүүгийн зардал	3,160	3,642	3,105	2,023	2,039	1%
Бусад зардал	1,633	396	351	351	27	(92%)
<b>Нийт зардал</b>	<b>12,688</b>	<b>13,007</b>	<b>9,659</b>	<b>5,269</b>	<b>4,503</b>	<b>(15%)</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(31)	(103)	(67)	(7)	(1)	(87%)
Виртуал хөрөнгө борлуулсны ашиг (гарз)	1,234	(1,497)	(412)	(2)	0	(100%)
Бусад олз (гарз)	-	-	-	-	(24)	-
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,291</b>	<b>585</b>	<b>(163)</b>	<b>1,730</b>	<b>(936)</b>	<b>(154%)</b>
Орлогын албан татварын зардал	180	470	(256)	186	(1,074)	(677%)
<b>Цэвэр ашиг</b>	<b>2,111</b>	<b>115</b>	<b>93</b>	<b>1,544</b>	<b>138</b>	<b>(91%)</b>
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз (гарз)	(155,722)	(19,466)	(29,819)	(8,678)	0	-
<b>Нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>(153,611)</b>	<b>(19,350)</b>	<b>(29,727)</b>	<b>(7,134)</b>	<b>138</b>	<b>(102%)</b>


2025 оны 6 сарын 30-ны байдлаар

сая төгрөг	2022	2023	2024	2024 H1	2025 H1	YoY
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	329	5	2	4	95%
Дансны болон бусад авлага	21,638	53,461	51,981	49,821	58,379	17%
Бусад санхүүгийн хөрөнгө	366	705	4,344	326	220	(33%)
Бараа материал	98	104	112	114	112	(2%)
Урьдчилж төлсөн тооцоо/ бусад эргэлтийн хөрөнгө	4,644	10,939	1,868	3,707	3,046	(18%)
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>26,749</b>	<b>65,539</b>	<b>58,310</b>	<b>53,970</b>	<b>61,760</b>	<b>14%</b>
Үндсэн хөрөнгө	419	429	260	326	280	(14%)
Виртуал хөрөнгө	11,833	88	350	178	341	91%
Биет бус хөрөнгө	187	262	151	2,291	140	(94%)
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,282	460	4,162	66	3,395	5,065%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	96,138	82,163	51,613	77,393	47,590	(39%)
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>109,859</b>	<b>83,403</b>	<b>56,536</b>	<b>80,254</b>	<b>51,745</b>	<b>(36%)</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>136,608</b>	<b>148,942</b>	<b>114,846</b>	<b>134,224</b>	<b>113,505</b>	<b>(15%)</b>
Дансны болон бусад өглөг	3,598	21,835	32,120	27,525	48,108	75%
Богино хугацаат зээл	2,578	6,853	5,866	3,154	6,419	104%
Богино хугацаат бондын өр төлбөр	2,603	370	370	370	0	(100%)
Богино хугацаат түрээсийн өглөг	866	608	1,320	140	725	419%
Урьдчилж орсон орлого	9,966	19,408	7,526	9,768	6,272	(36%)
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>	<b>19,611</b>	<b>49,074</b>	<b>47,202</b>	<b>40,957</b>	<b>61,525</b>	<b>50%</b>
Урт хугацаат түрээсийн өглөг	608	0	2,963	0	2,963	-
Урт хугацаат зээл	6,590	12,193	8,853	13,585	9,055	(33%)
Хойшлогдсон татварын өр	6,187	3,413	1,208	2,330	(57)	(102%)
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>13,385</b>	<b>15,606</b>	<b>13,024</b>	<b>15,915</b>	<b>11,962</b>	<b>(25%)</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>32,996</b>	<b>64,680</b>	<b>60,225</b>	<b>56,872</b>	<b>73,486</b>	<b>29%</b>
Өмч - хувьцаат	28,614	28,614	28,614	28,614	28,614	0%
Халаасны хувьцаа					(4,335)	-
Нэмж төлөгдсөн капитал	2,928	2,928	2,928	2,928	0	(100%)
Дахин үнэлгээний нөөц	52,793	28,362	1,804	19,684	(2,010)	(110%)
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14	14	14	0%
Хуримтлагдсан ашиг	19,264	24,344	21,262	26,112	17,735	(32%)
<b>Эздийн өмч</b>	<b>103,612</b>	<b>84,262</b>	<b>54,621</b>	<b>77,352</b>	<b>40,019</b>	<b>48%</b>

#	Хувьцаа эзэмшигч	2024.12.31	%	2025.06.30	%	Халаасласан хувьцаа	YTD	% change
1	Ардын Тэтгэврийн Данс ХХК	2,771,433	9.69%	2,128,408	8.71%	(643,025)	0	(0.98%)
2	Ард Бит	2,487,972	8.69%	1,910,699	7.82%	(577,273)	0	(0.88%)
3	Бруно Эдуард	2,109,997	7.37%	1,620,400	6.63%	(489,597)	0	(0.75%)
4	А.Сүхдорж	1,944,990	6.80%	1,493,668	6.11%	(451,322)	0	(0.69%)
5	Ч.Ганхуяг	1,649,252	5.76%	1,266,763	5.18%	(382,489)	0	(0.58%)
6	Г.Уянга	1,390,470	4.86%	1,067,775	4.37%	(322,695)	0	(0.49%)
7	И Ай Ти ХХК	1,390,064	4.86%	1,067,463	4.37%	(322,601)	0	(0.49%)
8	Ард Лизинг ХХК	857,118	3.00%	955,286	3.91%	(242,421)	340,589	0.91%
9	Голомт Кастодиан	900,000	3.15%	900,000	3.68%	0	0	0.54%
	ARDT	900,000	3.15%	900,000	3.68%	0	0	0.54%
10	Ард Венчурс ХХК	1,149,135	4.02%	889,974	3.64%	(266,715)	7,554	(0.38%)
11	С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.87%	0	0	0.27%
12	Ronoc Limited	443,816	1.55%	443,816	1.82%	0	0	0.26%
13	Ард Кредит ББСБ	395,680	1.38%	303,737	1.24%	(91,943)	0	(0.14%)
14	С.Оргил	390,937	1.37%	300,095	1.23%	(90,842)	0	(0.14%)
15	Г.Бат-Эрдэнэ	335,367	1.17%	290,515	1.19%	0	(44,852)	0.02%
16	Ард Даатгал	253,265	2.94%	253,265	1.04%	0	0	(1.90%)
17	Masik Enterprises Ltd.	321,078	1.12%	246,440	1.01%	(74,638)	0	(0.11%)
18	Х.Батхишиг	319,346	1.12%	245,102	1.00%	0	(74,244)	(0.11%)
19	Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.95%	0	0	0.14%
20	Монре Даатгал	193,814	0.68%	193,814	0.79%	0	0	0.12%
<b>Топ 20</b>		<b>19,992,972</b>	<b>71.92%</b>	<b>16,266,458</b>	<b>66.54%</b>	<b>(3,955,561)</b>	<b>229,047</b>	<b>(5.38%)</b>
Бусад		8,621,291	30.13%	8,179,445	33.46%	(379,465)	(62,381)	3.33%
<b>Эргэлтэд буй хувьцаа</b>		<b>28,614,263</b>	<b>100%</b>	<b>24,445,903</b>	<b>100%</b>	<b>(4,335,026)</b>	<b>166,666</b>	<b>0.00%</b>
Халаасны хувьцаа				4,335,026				
<b>Нийт гаргасан хувьцаа</b>		<b>28,614,263</b>		<b>28,614,263</b>				
Хувьцаа эзэмшигчид		18,790		18,158			(632)	
ARDT эзэмшигчид		3,115		3,056			(59)	
ADT эзэмшигчид (хүүхдүүд)		56,045		58,386			2,341	



# MSE:AARD хувьцааны арилжаа



## Түүхэн өгөөж (ногдол ашиг ороогүй)

Эхлэсэн	2021	Одоо
Одоогийн байдлаар		
<b>2005</b>	1,642x	396x
<b>2013</b>	18x	3.4x
<b>2019</b>	5x	46%

Нээлт	₮2,709	тэрбум төгрөг	2021	2022	2023	2024	2025	Эхний хагас жилд
<b>52 долоо хоног</b>	₮2,110 - ₮3,300	Хувьцааны эргэц	33.0%	13.0%	9.2%	6.8%		3.9%
<b>Хаалт (2025/06/30)</b>	₮3,015	Арилжааны дүн	72.2	23.1	8.7	5.3		2.9
<b>ЗЗҮ</b>	₮73,7 тэрбум							



Хүчтэй. Хамтдаа.